



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Үндэсний бичгээр хаягжуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Үндэсний хэл, бичгийн хэрэглээний уламжлалыг хадгалах, нийтийн болон албаны түвшинд хэрэглэж, хэвшүүлэх, иргэн бүрийн үндэсний хэл бичгийн боловсролыг төгөлдөржүүлж, нэгдмэл үнэт зүйл болгон төлөвшүүлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн харьяа төр захиргааны байгууллага, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн нэр, хаягийг үндэсний бичгээр бичиж, хаягжуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

2. Хаягжуулах ажилд шаардагдах зардлын төсвийг дүүргийн 2025 оны төсөвт тусган санхүүжүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3. Байгууллагынхаа нэр, хаягийг үндэсний бичгээр бичиж, хаягжуулах ажилд нэгдэж, хамтран ажиллахыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад уриалсугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D:/2025-togtooli

1150100001